



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/105

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн жижиг, дунд  
үйлдвэрийг дэмжих "Баянзүрх нэг зүрх төв"-ийн данс  
бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ашиглалтын шаардлага хангахгүй болж, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 12,500,000 (арван хоёр сая таван зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Дэу тоска 36-39 УБЧ улсын дугаартай тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээсээ Баянзүрх дүүргийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих "Баянзүрх нэг зүрх төв" (Г.Адъяасүрэн)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих "Баянзүрх нэг зүрх төв" (Г.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

3.Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс /Б. Батбаяр/-т даалгасугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА  М. БАЯРАА



115030000291